



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2025/078/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: buzmaa@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Албан шаардлага	10
Илрүүлэлт:	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396

Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 164

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,239,841.0 мянган төгрөг, үүний 1,194,046.2 мянган төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс, 45,794.8 мянган төгрөгийн санхүүжилт орон нутгийн төсвөөс санхүүжихээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 1,174,508.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 178,916.4 мянган төгрөгийг тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гараагүй болно.

Бусад асуудал

Сүхбаатар аймгийн Боловсролын газрын даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тайлант онд 10 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт 88.7 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	234,859,512.02	243,538,819.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	168,292,516.02	166,904,034.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	168,292,516.02	166,904,034.45
3121	Төгрөг	168,292,516.02	166,904,034.45
31211	Төрийн сангийн харилцах	168,292,516.02	166,904,034.45
35	БАРАА МАТЕРИАЛ	66,566,996.00	76,634,785.00
351	Түүхий эд материал	120,000.00	-
35130	Эм боох материал	120,000.00	-
354	Хангамжийн материал	66,446,996.00	76,634,785.00
35410	Бичиг хэргийн материал	3,130,540.00	1,219,300.00
35420	Аж ахуйн материал	63,213,456.00	75,095,385.00
35460	Хүнсний материал	103,000.00	320,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,364,807,984.00	2,304,043,756.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,364,807,984.00	2,304,043,756.64
392	Биет хөрөнгө	2,350,918,984.00	2,290,454,756.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,179,707,538.00	2,179,407,538.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162,306,028.82	-207,350,266.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,847,634.00	219,554,634.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,395,685.41	-89,362,074.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,546,755.90	86,385,009.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,741,063.59	-51,204,728.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	200,901,285.00	196,728,745.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-36,641,451.08	-43,704,099.84
393	Биет бус хөрөнгө	13,889,000.00	13,589,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-325,000.00	-625,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,714,000.00	12,714,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,599,667,496.02	2,547,582,576.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	500,000.00	1,579,990.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	500,000.00	1,579,990.00
413	Өглөг	500,000.00	1,579,990.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,579,990.00
4136	Бусад өглөг	500,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	500,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,599,167,496.02	2,546,002,586.09
51	Засгийн газрын хувь оролцоо	2,599,167,496.02	2,546,002,586.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	132,821,121.00	132,821,121.00
51101	Өмч: - төрийн	132,821,121.00	132,821,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,466,346,375.02	2,413,181,465.09
51210	Өмнөх үеийн үр дүн	2,319,391,681.25	2,466,346,375.02
51220	Тайлант үеийн үр дүн	146,954,693.77	-53,164,909.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,599,667,496.02	2,547,582,576.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,022,693,862.00	1,129,752,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,774,962.00	38,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	80,774,962.00	38,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,774,962.00	33,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,774,962.00	33,500,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	-	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	941,918,900.00	1,091,252,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854,918,900.00	1,012,252,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854,918,900.00	1,012,252,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,000,000.00	79,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,000,000.00	79,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	875,739,168.23	1,182,917,409.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,739,168.23	1,182,917,409.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,005,120.50	1,161,160,782.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,752,403.89	756,448,155.85
210101	Үндсэн цалин	337,316,377.56	496,322,646.89
210102	Нэмэгдэл	134,680,883.93	229,211,508.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	20,755,142.40	30,914,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,452,100.00	94,221,915.72
210201	Тэтгэврийн даатгал	53,347,300.00	64,744,899.82
210202	Тэтгэмжийн даатгал	6,276,100.00	7,472,067.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,021,000.00	3,703,033.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,255,300.00	3,600,608.73
210205	Эрүүл мэндийн даатгал	12,552,400.00	14,701,305.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,996,252.27	47,037,272.69
210301	Гэрэл, цахилгаан	20,612,860.27	10,986,032.69
210302	Түлш, халаалт	44,455,392.00	33,641,240.00
210303	Цэвэр, бохир ус	6,928,000.00	2,410,000.00
2105	Нормативт зардал	103,874,020.00	112,550,590.00
210502	Хоол, хүнс	103,874,020.00	112,550,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,657,200.00	12,145,871.00
210604	Урсгал засвар	11,657,200.00	12,145,871.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,496,600.00	3,033,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,496,600.00	3,033,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,776,544.34	135,723,677.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,259,637.00	26,326,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,325,500.00	10,433,340.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,191,407.34	98,964,227.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,734,047.73	21,756,627.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,730,300.00	8,793,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,730,300.00	8,793,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,747.73	12,962,727.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,747.73	12,962,727.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,954,693.77	-53,164,909.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	941,918,900.00	1,096,252,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		5,000,000
1200	Нийтлэг татварын бус орлого		5,000,000
120010	Борлуулалтын орлого /цэвэр/		5,000,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	941,918,900.00	1,091,252,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	854,918,900.00	1,012,252,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	854,918,900.00	1,012,252,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,000,000.00	79,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,000,000.00	79,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	801,946,654.89	1,092,940,981.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	801,946,654.89	1,092,940,981.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,212,607.16	1,071,184,354.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,752,403.89	751,488,771.57
210101	Үндсэн цалин	337,316,377.56	486,955,883.99
210102	Нэмэгдэл	134,680,883.93	232,933,237.58
210104	Урамшуулал	20,755,142.40	31,599,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,452,100.00	99,181,300.00
210201	Тэтгэврийн даатгал	53,347,300.00	67,443,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,276,100.00	7,934,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,021,000.00	3,967,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,255,300.00	3,967,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,552,400.00	15,869,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,996,252.27	47,037,272.69
210301	Гэрэл, цахилгаан	20,612,860.27	10,986,032.69
210302	Түлш, халаалт	44,455,392.00	33,641,240.00
210303	Цэвэр, бохир ус	6,928,000.00	2,410,000.00
2105	Нормативт зардал	103,922,420.00	111,187,700.00
210502	Хоол, хүнс	103,922,420.00	111,187,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	19,000,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,496,600.00	3,033,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,496,600.00	3,033,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,592,831.00	40,256,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,101,931.00	31,462,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,490,900.00	8,793,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,734,047.73	21,756,627.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,730,300.00	8,793,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,730,300.00	8,793,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,747.73	12,962,727.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,747.73	12,962,727.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	139,972,245.11	3,311,518.43
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,239,400.00	4,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,239,400.00	4,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,239,400.00	4,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,239,400.00	4,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,239,400.00	-4,700,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	134,732,845.11	-1,388,481.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,559,670.91	168,292,516.02
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	168,292,516.02	166,904,034.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	132,821,121.00	2,319,391,681.24	2,452,212,802.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	2,319,391,681.24	2,452,212,802.24
C07	Тайлант үеийн үр дүн	-	146,954,693.78	146,954,693.78
C08	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	132,821,121.00	2,466,346,375.02	2,599,167,496.02
D01	2024 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	132,821,121.00	2,466,346,375.02	2,599,167,496.02
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,821,121.00	2,466,346,375.02	2,599,167,496.02
D08	Тайлант үеийн үр дүн	-	-53,164,909.93	-53,164,909.93
D09	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	132,821,121.00	2,413,181,465.09	2,546,002,586.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,250,256,000.00	1,084,678,254.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,250,256,000.00	1,084,678,254.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,241,462,100.00	1,075,884,354.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	893,823,700.00	751,488,771.57
210101	Үндсэн цалин	608,868,200.00	486,955,883.99
210102	Нэмэгдэл	268,561,800.00	232,933,237.58
210104	Урамшуулал	16,393,700.00	31,599,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,215,800.00	99,181,300.00
210201	Тэтгэврийн даатгал	70,188,800.00	67,443,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,255,100.00	7,934,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,128,600.00	3,967,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,128,600.00	3,967,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,514,700.00	15,869,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,000,000.00	47,037,272.69
210301	Гэрэл, цахилгаан	17,000,000.00	10,986,032.69
210302	Түлш, халаалт	40,000,000.00	33,641,240.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,410,000.00
2105	Нормативт зардал	114,247,900.00	111,187,700.00
210502	Хоол, хүнс	114,247,900.00	111,187,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	19,000,000.00
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,033,300.00	3,033,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,033,300.00	3,033,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,141,400.00	44,956,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,347,500.00	36,162,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,793,900.00	8,793,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,793,900.00	8,793,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,793,900.00	8,793,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,793,900.00	8,793,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,091,252,500.00	1,091,252,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,091,252,500.00	1,091,252,500.00
122005	Орон нутгийн төсвөөс	1,091,252,500.00	1,091,252,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	168,292,516.02
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	179,866,761.76

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ. Илрүүлсэн 1.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт:

Байгууллагын 2 албан хаагчид нийт 1,680.2 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлтийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 (харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан (Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын хавсралт), 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан (Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх) журмыг тус тус зөрчсөн байна.

3.2 Зөвлөмж

1. Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалтыг мөрдөж, Орон нутгийн өмчийн албанд асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлэх.

2. Илрүүлэлт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оны 7-р сард ашиглалтад орсон цэцэрлэгийн барилга нурж сүүлийн 2 жил ашиглагдахгүй байгаа боловч тайлант онд 39.5 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 (жинхэнэ хэрэгжилтийн), 5.1.4 (үнэн зөв байх) Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2.1. (цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), 6.2.5 (ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон) зүйл заалтад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон үндсэн хөрөнгийг холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлж, данснаас хасах талаар асуудлыг шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урамшуулал болон нэмэгдэл цалинг олгохдоо тогтоол, дүрэм, журам баримтлаагүй	1	1,680.0			1	1,680.0		
Үндсэн хөрөнгөд үлдэх өртөггүй 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1						1	
Цэцэрлэгийн шинэ барилга нурж ашиглагдахгүй байгаа боловч элэгдлийн зардал тайлант онд тооцсон байна.	1						1	
Дүн	3	1,680.0			1	1,680.0	2	